



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/264

Хэрлэн сум

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх  
газар-419 дүгээр нээлттэй хорих ангид  
дэмжлэг үзүүлэх тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хорин гуравдугаар хуралдааны 2023 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.5 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих ангийн цагдан хорих байрыг нүүлгэхтэй холбоотой зардалд шаардлагатай 38,000,000 (гучин найман сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
..... дугаар сарын .....-ны өдрийн  
..... дугаар захирамжийн хавсралт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих анги  
шинэ байранд орохтой холбоотой шаардагдах зүйлсийн зардлын тооцоо

№	Шаардлагатай эд зүйлсийн нэр	Нийт үнэ
1	Камер	12,000,000
2	Гал тогооны тоног төхөөрөмж	14,000,000
3	Шаардлагатай эд хогшил (Ор, дэр, хөнжил, даавуу, гудас, бүтээлэг, бусад)	12,000,000
	Нийт шаардагдах зардал	38,000,000